



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 8 сарын 29 өдөр

Дугаар 350

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 24,778,557,549.00 /хорин дөрвөн тэрбум долоон зуун далан найман сая таван зуун тавин долоон мянга таван зуун дөчин есөн/ төгрөгийн балансын үнэ, 10,642,072,794.51 /арван тэрбум зургаан зуун дөчин хоёр сая далан хоёр мянга долоон зуун ерэн дөрвөн төгрөг тавин нэгэн мөнгө/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 9,6 км хатуу хучилттай авто замыг Зам, тээврийн хөгжлийн яаманд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Авсан арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЭРДЭНЭБАЯР

0000671